

Үзүүлэлтүүд:



<p>ДНБ 5.6% 2017 оны II-р улирлын байдлаар</p>	<p>ГШХО 8-р сард -123.8 сая ам.доллар</p>	<p>Төсвийн алдагдал -737 тэрбум төгрөг</p>	<p>Инфляци 5.8%</p>	<p>Чанаргүй зээл 1171 тэрбум төгрөг</p>	<p>Валютын нөөц 1.5 тэрбум ам.доллар</p>
<p>ДНБ-ий 5.6 хувиар өсөхөд бүтээгдэхүүний цэвэр татвар 24 хувь, үйлчилгээний салбар 9 хувиар өссөн нь нөлөөлөв.</p>	<p>Цэвэр ГШХО 7-р сарын байдлаар -123.8 сая ам.доллар өмнөх оны мөн үеэс 135.5 сая ам.доллараар буурав.</p>	<p>Төсвийн орлого 5491 тэрбум төгрөг, зарлага 5722 тэрбум төгрөг болж тэнцэл (737) тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.</p>	<p>Өмнөх сараас 0.2 хувиар нэмэгдэж, оны эхнээс 5.1 хувь өсч өмнөх оны мөн үеэс 5.8 хувь өссөн байна.</p>	<p>Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 1.2 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 7.4 хувиар нэмэгдэж 1169 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 8.7% байна.</p>	<p>Монголбанкны валютын нөөц 8-р сард өмнөх сараас 17.3 хувь буюу 236 сая ам.доллараар өсч 1599 сая ам.доллар болов.</p>

<p>\$ Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2454.29 ₮</p>	<p>Орон сууцны үнийн индекс 1.009 Өмнөх сараас 0.6%-иар өсч, өмнөх оны мөн үеэс 0.6%-иар буурав.</p>	<p>Монголбанкны бодлогын хүү 12%</p>
--	---	---

2017 оны хичээлийн шинэ жилийн нээлтэд Монгол Улсын хэмжээнд цэцэрлэг, сургуулийн насны 88,0605 гаруй хүүхдүүд суралцах байсан ч улсын цэцэрлэгт орж чадаагүй хүүхдийн тоо 57,373-т хүрсэн бол ерөнхий боловсролын сурагчдын тоо өмнөх жилээс 23,926 хүүхдээр нэмэгдсэн байна. Дэлхийн өрсөлдөх чадварын 2017 оны тайланд Монгол Улс нэг багшид ногдох сурагчийн харьцаагаар 27 сурагч оногдож нийт 63 орноос 59-рт эрэмбэлэгдэж байгаа юм.

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, хүснэгтээр оны эцсийн байдлаар үзүүлээ.



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд, өссөн дүнгээр (тэрбум ам.доллар, сая тонн)

Голлох бүтээгдэхүүн	2015 он		2016 он		2017 оны 9-р сар	
	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого
Чулуун нүүрс	14.4	0.6	25.7	9.7	25.5	1.7
Төмрийн хүдэр	6.3	0.2	6.1	2.4	4.3	2.3
Зэсийн баяжмал	1.4	2.3	1.5	1.6	1.0	11.5
Нийт	22	3	33	14	31	16

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


ДНБ

ДНБ 2017 оны 2-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 4.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 398.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засаг 5.6 хувиар өсөв. ДНБ 5.6 хувиар өсөхөд бүтээгдэхүүний цэвэр татвар 24 хувь, үйлчилгээний салбар 9 хувиар өссөн нь нөлөөлөв.



Төсөв

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 36.8 хувиар өсч, зарлага 5.6 хувиар буурсан бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 737 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 64 хувиар буурсан байна.




Валютын ханш

Есдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 210.3 төгрөг буюу 9.4 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 10 төгрөг буюу 0.4 хувиар нэмэгдэж 2454.29 төгрөг болов.



Инфляци

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2017 оны 9-р сард өмнөх сараас 0.2 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар өсч, өмнөх оны эцсээс 5.8 хувиар өсөв. 5.8 хувиар өсөхөд хүнсний бараа, боловсрол, орон сууц, ус, цахилгаан түлшний үнэ хамгийн их өссөн байна.



* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж ҮСХ, Монголбанк

Гадаад валютын нөөц


Гадаад валютын улсын албан нөөц 2017 оны 8-р сарын байдлаар 1599 сая ам.доллар болж өсөв. Энэ нь өмнөх сараас 17.3 хувь буюу 236 сая ам.доллараар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 40 хувь буюу 457 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.



* Эх сурвалж Монголбанк

MSE-20 индекс

2017 оны 9-р сард 1.3 их наяд төгрөгийн гүйлгээ хийж, 63.7 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеэс гүйлгээ 1 их наяд (5.8 дахин) төгрөгөөр өсжээ. ТОП-20 дундаж индекс 9-р сард 17244.8 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 2332.1 нэгж болж өсөв.



*Монголын хөрөнгийн бирж

Мөнгө

Мөнгөний нийлүүлэлт (M2) өмнөх оны мөн үетэй ойролцоо, өнгөрсөн сараас 1.6 хувиар өсч 14.7 их наяд төгрөгт хүрэв. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оныхоос 10.4 хувиар нэмэгдсэн бол өмнөх сараас 1.2 хувиар буурч нийт мөнгөний 6 гаруй хувийг эзэлж байна.



Хадгаламж

Нийт хадгаламж 2017 оны 9-р сард 10 их наяд төгрөг болж өмнөх сараас 142.9 тэрбум төгрөг буюу 1.4 хувиар өсөв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 23.7 хувиар буюу 1921.4 тэрбум төгрөгөөр өсөв. Валютын хадгаламжийн 74.1 хувийг төгрөгийн хадгаламж, 25.9 хувийг валютын хадгаламж эзэлж байна.



Зээл

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 9-р сард өмнөх сараас 1.2 хувиар нэмэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 7.4 хувиар нэмэгдэж 13.4 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1169 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 0.1 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 10.5 хувиар нэмэгдэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 8.7% байна.



Ипотекийн зээл


2017 оны 8-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 0.2 хувь (10.1 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 7.8 хувь (302.7 тэрбум төгрөг)-өөр нэмэгдэж нийт 4.1 их наяд төгрөгт хүрэв. Наймдугаар сард нийт 209 зээлдэгчид 10.1 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 92347-д хүрэв. 2017 оны наймдугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 99.5 хувь нь төгрөгийн зээл, 0.5 хувь нь валютын зээл байна.



Гадаад худалдаа

Гадаад
худалдаа

2017 оны эхний есөн сарын байдлаар нийт барааны эргэлт 7713 тэрбум төгрөг буюу 33 хувиар өсөв. Экспорт өмнөх сараас өөрчлөлтгүй, импорт өмнөх сараас 1.1 хувиар өсч худалдааны тэнцэл 1452 сая ам.доллар ашигтай гарав. Эхний 9 сарын байдлаар нүүрсний үнийн дүн (орлого) өнгөрсөн оны мөн үеэс 239 хувиар буюу 3 дахин өссөн үзүүлэлттэй байна.



* Эх сурвалж УСХ, Монголбанк

Гадаадын
шууд
хөрөнгө
оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2017 оны 8-р сард -123.8 сая ам.долларын сөрөг үр дүнтэй гарлаа. Харин өмнөх оны мөн үеэс 135.5 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. Өмнөх сартай харьцуулахад Монгол Улсаас гадаад руу гаргасан хөрөнгө оруулалт -0.2 сая ам.доллар байсан бол Монгол Улсад 148.4 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ.




* Эх сурвалж Монголбанк


Монгол Улсын гадаад өр

Гадаад өр

2017 оны хоёрдугаар улиралд Засгийн газрын нийт гадаад өр 6 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 25 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 3 хувь (171 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 1 хувь (257 сая ам.доллар)-иар тус тус өссөн байна. Тайлант улиралд нийт Улсын гадаад өрийн 24 хувийг засгийн газрын өр, 7 хувийг Төв банкны өр, 9 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 31 хувийг бусад салбаруудын өр, 28 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨРИЙН БҮТЭЦ ХУВИАР



Эх сурвалж Монголбанк

Сарын онцлох үйл явдал

9.26

Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсын эдийн засгийг 4 хувиар өснө гэж таамаглав. АЗХБ-ны ахлах эдийн засагч Деклан Магий: Монголын эдийн засаг оны эхний хагасаар 5,3 хувиар өссөн нь өнгөрсөн жилийн 1,3 хувьтай харьцуулахад сайн үзүүлэлт. Энэ нь нүүрсний олборлолт сэргэж, экспорт нэмэгдсэнтэй холбоотой. Нүүрсний олборлолт өссөн, БНХАУ-ын нүүрсний эрэлт сайн байна гэж үзсэн учраас эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж авч үзлээ. Бодит гүйцэтгэлд таамагас дээгүүр гарахад БНХАУ-ын эдийн засгийн өсөлт, зэсийн үнэ өсөх зэрэг хүчин зүйлс нөлөөлж болно. Монгол улсын ДНБ-ний өсөлт 2017 онд 4 хувиар, 2018 онд 3 хувиар өснө гэж таамаглаж байгаа бөгөөд инфляцийн түвшин 2017 онд 3 хувь 2018 онд 3,4 хувь болно гэж таамагласан. Харин урсгал дансны алдагдал энэ онд -6,4 хувь, ирэх онд -8,5 хувь гэж таамаглаж байна.

9.27

Манай улсын санхүүгийн зах зээлийн 95 хувийг банкны салбар дангаар бүрдүүлдэг. 2017 оны 8-р сарын байдлаар арилжааны банкуудын зээлийн дундаж хүү 20.1 хувь байгаа юм. Банкнууд хадгаламжийн хүүн дээр үйл ажиллагааны зардал, ашгаа нэмээд зээлийн хүүгээ тогтоодог. ОУВС-ийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд нийт Арилжааны банкуудад Активийн чанарын үнэлгээ (AQR) хийж эхний байдлаар 11-р сарын 30-нд тайланг танилцуулна. Тэр үед банкны салбар дахь дангаар ноёлсон эрүүл бус байдал бага багаар цэгцрэх төлөвтэй.